



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Э.БАТШУГАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.04.20 № 19

Эрүүл мэндийн салбарын
зардлын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу гишүүн нь Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдээс хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар мэдээлэл авах зорилгоор танай салбарын бодлого, авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээтэй холбогдуулан Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газраас эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг 2026 онд 75 хүртэл хувиар нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэр нь салбарын хүний нөөцийн тогтвортой байдал, үйлчилгээний чанар, хүртээмжид чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм. Үүнтэй холбогдуулан эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн нэмэгдлийн хэрэгжилтийн талаар дараах асуудал тус бүрээр:

-Цалингийн нэмэгдлийн бодлогын шийдвэрийн эрх зүйн үндэс, гарсан огноо, хэрэгжүүлэх үе шат, нөхцөлийг дэлгэрэнгүй танилцуулга;

-2026 оны байдлаар уг шийдвэрийн хэрэгжилтийн явц, бодит гүйцэтгэл (хэдэн хувьд хүрсэн, нэмэгдлийг албан тушаалын ангилал зэрэглэлээр)-ийн талаар мэдээлэл;

-Эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчдын цалингийн нэмэгдлийн талаарх бодлогын талаар;

-Цалингийн нэмэгдлийг санхүүжүүлэх эх үүсвэрийг талаарх тодорхой мэдээлэл (улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, бусад эх үүсвэр);

-Цаашид уг нэмэгдлийг тогтвортой хадгалах санхүүгийн чадавх, дунд хугацааны төсвийн хүрээний бодлоготой хэрхэн уялдуулж байгаа талаар.

2. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2027 онд Дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүргэх зорилтыг тусгасан. Энэхүү зорилт нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн дарамтыг бууруулах стратегийн ач холбогдолтой болно. Дээрхээс үндэслэн эрүүл мэндийн

2026000055

салбарын төсвийг ДНБ-ий 5 хувьд хүргэх зорилтын хэрэгжилтийн талаар дараах асуудал тус бүрээр:

-Дээрх зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн болон бодлогын баримт бичгийн уялдааны талаарх мэдээлэл (жишээлбэл: улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, салбарын стратеги);

-2026-2027 онд эрүүл мэндийн салбарын төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ бодитоор хэдэн хувь байгаа, цаашид 5 хувьд хүргэх үе шат, тооцоо, төлөвлөлтийн талаар;

-Санхүүжилтийг нэмэгдүүлэх эх үүсвэр, бүтэц (татварын орлого, даатгалын сан, гадаад зээл, тусламж гэх мэт)-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

-Зорилтыг хангах хүрээнд хэрэгжүүлэх бодлогын шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийн мэдээлэл (үр ашиг, зардлын хяналт, худалдан авалт, анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт);

-Хэрэв зорилтот түвшинд хүрэхэд эрсдэл, саад бэрхшээл байгаа бол түүнийг даван туулах бодлогын шийдлийн талаар.

Эдгээр асуудал нь эрүүл мэндийн салбарын тогтвортой санхүүжилт, хүний нөөцийн бодлого, иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарт шууд нөлөөтэй тул бодит мэдээлэл, тоон үзүүлэлт, судалгаанд суурилсан хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Т. МӨНХСАЙХАН

2026000055